



ОЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,  
Цахим хуудас: www.afccp.gov.mn

*J. Фаст*  
*29/5*

2024.05.27 № 02/1006  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендерийн баримт бичгийг  
хянасан тухай**

Танай газраас зарласан “Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх” ОйГ/20240101107 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Шим” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

1. Тендерийн баримт бичгийн ТШЗ 1.2-т “Багц № 1: Булган, Орхон, Сэлэнгэ аймгийн ойн сан бүхий сумдын ойн санд гэж, Багц № 3: Хөвсгөл, Хэнтий, Төв аймгуудын ойн сан бүхий сумдын ойн санд” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа газар зүйн байрлалыг харгалзан багцалсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно” гэж заасны дагуу багцалсан байна.

2. Тендерийн баримт бичгийн тэмцлийн ажилд хэрэглэгдэх бэлдмэл бодисын техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад “3. Bacillus thuringiensis Bt-MN01 эсхүл түүнтэй дүйцэх био бэлдмэл” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрээс худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичигт заана” гэж, 8.2-т “Энэ хуулийн 8.1-д заасан барааны нэр, төрлийн жагсаалтыг эдийн засаг, хөгжлийн, хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, Засгийн газар батална” гэж, 10 дугаар зүйлийн 10.4-т “Бараа худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулахад энэ хуулийн 8.2-т заасан барааг бусад бараанаас тусад нь багцална” гэж мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 90 дугаартай тогтоолын хавсралтаар баталсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах

0002172

чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-ын 8.1-д "Малын эм, био бэлдмэл" гэж тус тус заасан байна.

Захиалагч тус тендерийн баримт бичгийг боловсруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлт оруулан, хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.

Түүнчлэн тус газраас 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/908 дугаартай албан бичгээр уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер хүлээн авах, нээлт хийх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн байх хугацаанд тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсан байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг үүгээр анхааруулж байна.

ОРОН ТООНЫ ГИШҮҮН



О.БАТМӨНХ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,  
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024-05-27 № 02/1004  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендерийн баримт бичгийг  
хянасан тухай**

Танай газраас зарласан “Ойн шавжтай агаарын хөлөг ашиглан тэмцэх” ОйГ/20240101108 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Шим” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

1. Тендерийн баримт бичгийн ТШЗ 1.2-т “Багц № 1: Улаанбаатар хотын Ногоон бүс, Горхи-Тэрэлж БЦГ, Богдхан-уул ДЦГ, Төв аймгийн Эрдэнэ сум, Архангай Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг сумдын ойн санд гэж, Багц № 3: Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл, Нөмрөг, Баянтэс, Баянхайрхан сумд, Увс аймгийн Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Малчин сумдын ойн санд гэж, Багц № 4: Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Шинэ-Идэр, Төмөрбулаг, Цэцэрлэг сумд, Увс аймгийн Наранбулаг, Түргэн, Сагил, Улаангом сумдын ойн санд” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа газар зүйн байрлалыг харгалзан багцалсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно” гэж заасны дагуу багцалсан байна.

2. Тендерийн баримт бичгийн тэмцлийн ажилд хэрэглэгдэх бэлдмэл бодисын техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад “3. Bacillus thuringiensis Bt-MN01 эсхүл түүнтэй дүйцэх био бэлдмэл” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрээс худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичигт заана” гэж, 8.2-т “Энэ хуулийн 8.1-д заасан барааны нэр, төрлийн жагсаалтыг эдийн засаг, хөгжлийн, хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, Засгийн газар батална” гэж, 10 дугаар зүйлийн 10.4-т “Бараа худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулахад энэ хуулийн 8.2-т заасан барааг бусад бараанаас тусад нь багцална” гэж мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 90

дугаартай тогтоолын хавсралтаар баталсан “ Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ын 8.1-д “Малын эм, био бэлдмэл” гэж тус тус заасан байна.

Захиалагч тус тендерийн баримт бичгийг боловсруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлт оруулан, хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.

Түүнчлэн тус газраас 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/908 дугаартай албан бичгээр уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер хүлээн авах, нээлт хийх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн байх хугацаанд тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсан байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг үүгээр анхааруулж байна.

ОРОН ТООНЫ ГИШҮҮН



О.БАТМӨНХ